



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

᠒᠐᠒᠐ оны ᠐᠑ сарын ᠒᠔ өдөр

Дугаар ᠑/᠕᠖᠑

Чингис хот

Инженерийн хийцтэй худаг хүлээн авах  
ажлын комисс томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын хамтарсан 2005 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 101/189/194 дугаар тушаалаар баталсан "Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн завсарлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам"-ын 4.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил" төсөл болон орон нутгийн төсөв хөрөнгөөр хөдөөгийн хүн ам, мал аж ахуй, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор 18 сумын нутаг дэвсгэрт 2020 онд шинээр гаргасан 28 инженерийн хийцтэй худгийн ажлын гүйцэтгэлийг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Ж.Энх-Амгалан	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Ч.Мөнх-Эрдэнэ	"Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл"-ийн аймаг, сумдын төслийн ажилтан
Гишүүд:	Г.Ирээдүймөнх	Хүнс, хөдөө аж ахуйн газрын Бэлчээр, тэжээл, усан хангамж хариуцсан мэргэжилтэн Аймаг, сумдын төслийн ажилтан Сумдын Засаг дарга Сумдын Хүнс, хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн Гүйцэтгэгч компанийн төлөөлөл

2. Шинээр гаргасан инженерийн хийцтэй худгийг холбогдох стандарт, техникийн тодорхойлолт, баримт, материалын шаардлагын дагуу хүлээн авахыг комиссын дарга /Ж.Энх-Амгалан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010874